

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм оюутнууд аа,
Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүрдэд ажил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР


БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Валютын ханш

	АНУ доллар	1,991.67
	Евро	2,188.55
	Японы иен	16.49
	Швейцар франк	2,015.45
	Шведийн крон	233.64
	Английн фунт	3,054.43
	ОХУ-ын рубль	30.89
	БНХАУ-н юань	314.95
	БНСУ-ын вон	1.75
	Канадын доллар	1,514.65
	Малайзын ринггит	563.88
	Туркийн лира	681.76



Санхүүгийн зах зээлийн 2025 он хүртэлх шинэчлэл хөгжлийн хөтөлбөрийг хэлэлцүүлээ

Санхүүгийн зохицуулах хороо санаачлан Сангийн яам, Монгол банктай хамтран Монгол улсын санхүүгийн салбарын алсын харааг тодорхойлох “2025 он хүртэл хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулаад байна. Хөтөлбөрт мэргэжлийн оролцогчдын саналыг тусгах анхны хэлэлцүүлгийг аравдугаар сарын 30-ны өдөр Банк санхүүгийн академийн байранд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд: бичил санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх бодлого, даатгалын зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх бодлого, үнэт цаасны зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх бодлого, банкны салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх бодлого гэсэн дэд хэлэлцүүлэг өрнөж салбар тус бүрийн оролцогчид хөтөлбөрт тусгавал зохих асуудлын талаар саналаа өглөө. Өрсөлдөх чадвар бүхий, олон улсын санхүүгийн зах зээлд нэвтэрсэн, үр

ашигтай зохистой хяналт зохицуулалт бүхий санхүүгийн системийг бий болгоно хэмээн алсын харааг тодорхойлсон дээрх хөтөлбөр нь үндсэн таван зорилготой. Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, зохицуулалттай этгээдүүдийн саналыг хөтөлбөрт тусгасны дараа үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулах юм.



Төрийн албан хаагчдын цалинг нэмэхээр болов

Ирэх сарын 1-нээс Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхээр болжээ.


Ингэхдээ Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, үйлчилгээний салбарт хамаарагддаг албан хаагчдын цалинг нэг ижил мөнгөн дүнгээр нэмэгдүүлэх юм байна.

Засгийн газраас энэ оны төсөвт цалин тэтгэврийг нэмэх зорилгоор 130 тэрбумыг суулгасан.

Харин тусгай албан хаагчдын цалинг ирэх долдугаар сарын 1-нээс, Төрийн удирдах албаны ажилтнуудын цалинг аравдугаар сарын 1-нээс нэмэгдүүлэхээр болсон байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл -144.6 тэрбум төгрөг байна





Хятадын юань америк долларыг “алгадав”

Монголбанкны валютын ээлжит дуудлага худалдаа онгөрсон долоо хоногийн Пүрэв гарагт болов. 2009 оны эдийн засгийн хямралын үед Олон улсын валютын сангийнхан манай долоо хоногийн Мягмар, Пүрэв гаригт валютын дуудлага худалдаа зохион байгуулахыг зөвлөж, хэвшүүлсэн юм.

Өмнө нь манай валютын захад гэнэтийн савлагаа үүсэхэд зохицуулах механизм байгаагүй. Хямралын үед ам.долларын ханш сарын хугацаанд 500 төгрөгөөр нэмэгдэн, 1,700-г давахад Монголбанкныхан “Найман шарга” дээр валют авчирч зарж интервенц хийсэн сураг дууддаг. Механизм байхгүй болохоор болхи арга хэрэглэсэн бололтой. Дуудлага худалдаа нь валютын зах зээлийн “толь” болоод удаж байна. Банкууд их хэмжээний ам.доллар Товбанкинд худалдахыг санал болговол зах зээлд илүүдэл үүссэнийг илэрхийлнэ. Харин Монголбанкаас ам.доллар худалдаж авахыг хүсвэл “ногоон” дутагджээ гэдгийг хэлнэ. Зах зээлд “ногоон” илүүдвэл ханш нь буурна, хомсдвол осно.

Пүрэв гарагийн дуудлага худалдаагаар банкууд 1,982-1,982.95 төгрөгийн ханшаар 6.65 сая ам.доллар худалдах санал Монголбанкинд ирүүлжээ. Мөн 319.30 төгрөгийн ханшаар таван сая юань Товбанкинд худалдах санал тавьсан байна. Монголбанк доллар ч, юань ч худалдаж авалгүй зах зээлд нь үлдээжээ. Мөн банкууд 20 сая ам.доллар худалдах своп хэлцлийн санал ирүүлсэн аж. Саналыг биелүүлж, 20 сая ам.долларыг худалдан авчээ. Үүнээс долоо хоногийн өмнөх дуудлага худалдаагаар валют худалдах болон худалдан авах санал ирэлгүй зах зээл тэнцвэргэсэн юм.

Зах зээлд валютын илүүдэлтэй байгаа учраас ханш буурах нь тодорхой. Монголбанкны зарласан албан ханшаар ам.доллар 1,970 төгрөгтэй тэнцүү байна. Онгөрсон сарын 25-нд ам.доллар зарласан ханш 1,993 төгрөгт хүрсэн нь түүхэн дээд цэг нь юм. Үүнээс ханш 23 төгрөгөөр буураад байгаа нь энэ. Сүүлийн нэг жилийн хугацаанд “ногоон”-ы ханш буурсан сар ховор. 1,890 төгрөгт дохоод байсан ам.долларын ханш онгөрсон оны наймдугаар сард 1,800 руу “гулссан”. Мөн энэ сард ханш буурч байна.

“Найман шарга” худалдааны төвийн ченжүүд ам.долларыг 1,968 төгрөгөөр худалдан авч, 1,973-аар борлуулж байна. Түүнчлэн юанийг 315.5 төгрөгөөр худалдан авч, 316.5-аар зарж байлаа. Валютын ченж Ш.Буян “Зах зээлд юань элбэг байна. Иймээс юанийн ханш буурч байгаа. Үүнийг дагаад долларын ханш буурч байна” гэж яриу. Тэрбээр “Хятадууд их хэмжээний юань оруулж ирж байх шиг байна” гэж нэмж хэллээ.

Үнэхээр ч юань Монгол руу урсдаг цаг үе ирчихээд байна. Хятадууд одийд Монголоос ноолуур худалдаж авахаар багагүй юань гуйвуулдаг билээ. Монгол Улс жилд 7,000 тонн ноолуур бэлтгэдэг. Үүний дийлэнхийг хятадууд худалдан авдаг уламжлалтай. Манайхаас хятадууд 4,000 тонн ноолуур худалдан авдаг. Ингэхдээ нэг килограммыг нь 50 мянган төгрөгөөр худалдан авна гэж тооцвол 600 сая юань манай зах зээлд нийлүүлэх юм.

Юанийн ханшийг дагаад ам.долларынх буурч буйд учир бий. Хятадууд юанийнхаа ханшийг ам.доллартай уячихсан. Манай экспортын бүтээгдэхүүний 90 хувийг Хятадын зах зээлд гардаг. Импортын 60 хувиа Хятадаас татдаг. Иймээс юань, доллар хоёр манай зах зээлд ч уяатай хэвээр байдаг юм. Өнөөдөр 6.25 юань нэг ам.доллартай тэнцэж байгаа. Долоон жилийн өмнө нэг ам.доллар 6.8 юаньтай тэнцэж байсан юм. Хятадууд уяагаа үл мэдэг сулруулсаар байна. Тэд долоон жилийн хугацаанд юанийн ханшийг ам.долларын эсрэг долоон хувиар чангаруулаа. Урд хорш нэг юанийн ханшийг нэг долларынхтой тэнцүүлэх зорилттой гэж ярьдаг юм.

Ноолуур худалдаж авах 600 сая юанийг хорвүүлбэл 90 гаруй сая ам.доллар болно. Ийм хэмжээний ам.долларын нийлүүлэлт

зах зээлийг хөдөлгөөнд оруулах чадалтай болжээ. Монгол Улсын сарын гадаадын худалдааны импорт дунджаар 230 сая ам.доллартай тэнцдэг болсон. Тэгэхээр 90 сая “ногоон” нэг сарын импортын 40 хувийг хангах мөнгө юм. Өмнөх жилүүдэд манай гадаад худалдааны урсгал сард 600 сая ам.доллар хүртэл осч байсан түүх ч бий. Тэр үед 90 сая ам.доллар зах зээлд орж ирэхэд ямар ч нөлөө үзүүлэхгүй байсан.

2013 онд гадаадын хөрөнгө оруулалт эрс буурахад арилжааны банкууд Товбанкаас сар бүр ийм хэмжээний “ногоон” худалдан авахыг шаардаж байлаа. Дэлхийн зах зээлд газрын тосны үнэ хямдарсан, иргэд импортын барааны хэрэглээгээ танасан нь импортын хэмжээг үлэмж бууруулжээ. Энэ жилдээ импортын хэмжээ өсөхгүй байх төлөвтэй байгааг Монголбанкныхан дуулгасан. 2015 он эхний улирлын байдлаар манай улс гадаад худалдааны тэнцэл 376 сая ам.долларын ашигтай гараад байна. Гадаад худалдаа ашигтай байгаа нь цаашид ам.долларын ханш тогтвортой бөгөөд цаашид өсөхгүй байх нэгэн нөхцөл болж буй.

Харин манай улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт алдагдалтай болсон. Он гарснаар манайхаас 100 сая ам.долларын гадаадын хөрөнгө гарчээ. Дулааны улирал эхлэхийн сацуу “Оюутолгой”, “Тавантолгой” зэрэг томоохон төслүүд хөдлөхөөр яриа хэлэлцээ хийж эхлэв. Эдгээрээс гадна Тавдугаар цахилгаан станц, Тавантолгой цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх сураг сонсогдож байна. Удахгүй Засгийн газар ч төсвийн алдагдлыг нөхөх “ногоон” зээлэхээр гадаад руу мордох гэнэ. Хөгжлийн банк Туркийн Экспорт, импортын банкнаас зээл авахаар тохиролцож буй. Монголын зах зээл рүү “ногоон” урсах цаг ойртоод л байна. Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал Монголын эдийн засгийн чуулганы үеэр “Энэ жилд нэг тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх төлөвтэй байгаа” гэж ярьсан.


Олон улсын валютын сан манай улсыг гадаад төлбөрийн тэнцлийг 1.4 тэрбум ам.долларын алдагдалтай гарах магадлалтай гэж тооцсон. Гадаад худалдааны алдагдал багасч буй нь нийт төлбөрийн тэнцлийн алдагдлыг ч бууруулах гэнэ. Нэг тэрбум ам.долларын санхүүжилт татахад манай улс валютын ханшийн эрсдэлээс хамгаалах “бамбай”-тай болох аж.

Импортын хэмжээ буурч буй нь олон эерэг нөлөө үзүүлж байгаа. Монгол Улс 1.3 тэрбум ам.долларын валютын нооцтэй болсон. Импорт буурах тусам нооцийн “чадвар” сайжирч байна. Энэ нь одоогийн байдлаар Монгол Улсын валютын нооц таван сарын импортын хэрэглээг худалдаж авахад хүрэлцэхүйц юм.

Нийтлэлч Баабар Монголын эдийн засгийн чуулганд оролцож, илтгэл тавихдаа Монголбанкны валютын нооц дууссан гэж мэдэгдсэн. Тэрбээр Хятадын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн хүрээнд авсан юанийг валютын нооцоосоо хасаж тооцох ёстой гэж үздэг. Харин Монголбанкныхан Ардын банкнаас авсан юаниа гурван жилийн дараа эргүүлж өгнө. Эсвэл эргүүлж өгөх хугацаагаа дахин сунгасан ч болно. Ер нь хожим төлөх зээлийг валютын цэвэр албан нооцоос хасч тооцдоггүй гэж тайлбарладаг. Дэлхийн жишигт ч бэлэн байгаа цэвэр нооцоо хожим төлөх зээлийг хасч тооцдоггүй аж. Валютын нооц ч хүрэлцээтэй байна.


Ер нь ам.долларын ханш 2,000 төгрөг давах нь гэсэн хүлээлт намжиж, сулрах хандлага давамгайлав. Ханшийн зөрүүнээс ашиг олох сонирхлоор хар захаас ам.доллар худалдаж авдаг хүмүүсийн санаархал ч татарч байгаа биз. Том төслүүдийн хөрөнгө оруулалт эхэлбэл ам.долларын орох урсгал нэмэгдэж, ханш буурах нь дамжиггүй. Тэгвэл “доллар цуглуулагчид” ашиг биш, алдагдал хүлээнэ. Хятадын юанийн урсгал нэмэгдэж, ам.долларыг нэг сайн “алгадаад” авлаа.

Өнөөдөр Монголбанк валютын ээлжит дуудлага худалдаагаа хийнэ. Тэндээс хэрэг явдал хэрхэн орнох нь харагдана.



Шинэ журамд шилжсэнээр татвар төлөгчдийн бухимдал үгүй болсон

Авто тээврийн хэрэгслийн татвар төлөлт энэ жилээс эхлэн НИТХ-аас баталсан шинэ журмаар хэрэгжиж байгаа билээ. Шинэ журмын хэрэгжилт, татвар төлөлтийн явцын талаар Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн ахлах байцаагч С.Гансүрэнгээс тодрууллаа.



эрмэлзэж байна.

-Шинэ журам нэгдүгээр сарын сүүлээр батлагдаж, хоёрдугаар сарын сүүлээс хэрэгжиж эхэлсэн. Нэг, хоёрдугаар сард татвараа төлөх ёстой байсан 1, 6, 2, 7-гоор төгссөн тээврийн хэрэгсэл татвараа одоо төлбөл торгууль, алданги тооцох уу?

-Журам хэрэгжиж

-Авто тээврийн албан татвар хураах ажиллагаа энэ жилээс шинэ журамд шилжсэн. Энэ журмын талаар иргэдэд мэдээлэл өгөхгүй юу?

-НИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны нэгдүгээр 26-ны өдрийн 28 тоот тогтоол гарсан.

Тогтоолд албан татвар, төлбөр хураах шинэ журам баталсан. Шинэ журамд тээврийн хэрэгслийн улсын дугаар нь 1, 6-гаар төгссөн бол нэгдүгээр сард 2, 7-оор төгссөн бол хоёрдугаар сард, 3, 8-аар төгссөн бол гуравдугаар сард, 4, 9-оор төгссөн бол дөрөвдүгээр сард, 5, 0-ээр төгссөн бол тавдугаар сард албан татвар, төлбөрөө төлөхөөр зохицуулалт хийж өгсөн. Мөн албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны хоёрдугаар сарын 17-ны өдрийн А/143 тоот захирамж гарсан.

Энэ шинэ журам тээврийн хэрэгсэл эзэмшигч Иргэд, ААН, байгууллагуудыг оочер дараалал үүсгэхгүй, шуурхай, цаг хэмнэсэн үйлчилгээ үзүүлэх, ачааллыг тэнцвэржүүлэх зорилготой.

-Өнгөрсөн жил автомашин эзэмшигчид татвараа төлөхөөр маш их дараалал үүсгэж, бухимдаж байсан шүү дээ. Шинэ журам гарснаар энэ байдал арилсан гэж ойлгож болох уу?

-Ачаалал мэдэгдэхүйц багассан. Манай Баянзүрх дүүргийн салбар комисс л гэхэд Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээнээс гадна Дүнжингарав төвд нэг цэгийн үйлчилгээ нээж тээврийн хэрэгсэл эзэмшигчидээ хоёр газар хүлээж авч үйлчилж байна.

Дүүргийн Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээ өглөө 08.30-17.30 цагт, Дүнжингарав худалдааны төвд ажиллаж байгаа Нэг цэгийн үйлчилгээ ажлын өдрүүдэд 09.00-18.00, амралтын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд ажиллаж байна.

Дүнжингарав худалдааны төв долоо хоног бүрийн Даваа гарагт амардаг боловч Авто тээврийн татвар, төлбөр хураах салбар комиссын хүсэлтээр Даваа гарагт ажиллаж, иргэдийг албан татвар, төлбөрөө төлөх бололцоогоор хангасан. Гэх мэтээр иргэдэд аль болох хурдан шуурхай, ачаалал үүсгэхгүй ажиллахыг

эхэлж байгаа учраас оны эхний саруудад авто тээврийн татварт хамрагдахаар батлагдсан ч, тухайн сардаа багтаж албан татвар, төлбөр төлөөгүй байгаа тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, ААН, байгууллагуудад ямар нэгэн торгуулийн арга хэмжээ авахгүй.

Харин тавдугаар сарын 31-нээс хэтрүүлэн, хуульд заасан хугацаандаа албан татвар, төлбөрөө төлөөгүй авто тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, ААН, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу торгуулийн арга хэмжээ авна.

-Иргэдийн татвар төлөлтийн идэвх хэр байна вэ?

Манай дүүргийн хувьд, өнөөдрийн байдлаар 21,147 мянга орчим тээврийн хэрэгслээс 1,214,827.0 сая төгрөгийн албан татвар, Агаар бохирдлын төлбөрөөр 80 сая төгрөг, Зам ашигласны төлбөрөөр 596225,9 мянган төгрөгийн орлогыг Нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна. Баянзүрх дүүргэрт 98 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн ч 2014 онд 70 орчим мянган тээврийн хэрэгсэл албан татвар, төлбөрт хамрагдсан. Үлдсэн 28 мянга орчим тээврийн хэрэгсэл нь эвдэрсэн, ашиглах боломжгүй болсон хилээр гарсан зэрэг шалтгаантай авто тээврийн татвар, төлбөрт хамрагдахгүй тээврийн хэрэгсэл байгаа.

Иргэд, ААН, байгууллагууд эвдэрсэн, ашиглах боломжгүй, хилээр гарсан тээврийн хэрэгслээ Авто тээврийн газрын бүртгэлээс цаг тухайд нь хасалт хийлгэдэггүйгээс нь тээврийн хэрэгслийн бодитой тоон мэдээллийг гаргахад хүндрэл учирдаг.

Тиймээс тээврийн хэрэгслийн бүртгэлээс хасалт хийлгэж амжаагүй иргэд, зохион баримтуудыг бүрдүүлэн Авто тээврийн газарт өгч хасалтаа хийлгэх шаардлагатай.

Хасалт хийгдэх ёстой тээврийн хэрэгслүүд Авто тээврийн газарт бүртгэлтэй хэвээр байх тохиолдолд жил бүр татварын ногдол үүсч, хуримтлагдан иргэд, ААН, байгууллагын нэр дээр татварын өр үүссээр байдгийг хэлмээр байна. Иймд иргэд, ААН, байгууллагууд ашиглах боломжгүй болсон тээврийн хэрэгслээ Авто тээврийн газрын бүртгэлээс заавал хасалт хийлгэж, татвар төлөх эрх үүргээ дуусгавар болгохыг анхааруулья.



Нийслэлд тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, автозам ашигласны төлбөр хураах ажлын тухай

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Авто зам ашигласны төлбөрийн хураах журмын хэрэгжилтийг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад албан татвар, төлбөрөө хуулийн хугацаанд төлөх нөхцөл бололцоог бүрдүүлэн өгч төрийн үйлчилгээг иргэдэд хүрч нэг цэгээс үзүүлэх, татвар төлөгчдийг шинэчлэн бүртгэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх үндсэн дээр нийслэлийн замын санг бүрдүүлэх зорилготой.

Үндэслэл

Энэхүү арга хэмжээг Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Нийслэлийн засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 11 өдрийн А/128 тоот захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн А/143 тоот захирамжийн дагуу зохион байгуулж байна.

□ “Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 7 дугаар зүйл 7.1-д зааснаар иргэд автотээврийн хэрэгслийн албан татвараа жилд нэг удаа 6 дугаар сарын 1-ний дотор;

□ “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулийн 9 дүгээр зүйл 9.3-д төлбөр төлөгч нь Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албандаа төлөх;

□ Нийслэлийн засаг даргын 2015 оны А/128 тоот захирамжаар батлагдсан 3.3 нийслэлд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуй нэгж байгууллага нь нийслэлийн автозам ашигласны төлбөрийг тухайн жилийн 6 дугаар сарын 10-ны дотор төлөхөөр зохицуулагдсан байна.

Онцлог тал

НИТХ-ын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн №28 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл төлбөрийн тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх журам” батлагдсан.

1. Энэ журмын 3.4-т Автотээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг тээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлийн оронгийн тоогоор дараахь дарааллаар тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах: Үүнд:

- 1, 6 тоогоор төгссөн бол нэгдүгээр сард;
- 2, 7 тоогоор төгссөн бол хоёрдугаар сард;
- 3, 8 тоогоор төгссөн бол гуравдугаар сард;
- 4, 9 тоогоор төгссөн бол дөрөвдүгээр сард;
- 5, 0 тоогоор төгссөн бол тавдугаар сард тус тус төлөхөөр заасан.

Энэ оны хувьд 1, 6, 2, 7-гоор төгссөн автотээврийн хэрэгсэл эзэмшигчид 2 дугаар сард багтаан албан татвар, төлбөрөө төлөх шаардлагатай.

2. Журмын 2-т автотээврийн хэрэгслийн бүртгэлийг боловсронгуй болгож Нийслэлд бүртгэлтэй идэвхитэй тээврийн хэрэгслийн нэгдсэн сан үүсгэх

Энэ ажлын хүрээнд автотээврийн хэрэгслийн бааз цэгцлэх ажлыг зохион байгуулж, эвдэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах үйл ажиллагааг хялбаршуулсан байдлаар хийнэ.

3. “Smartcar” мэдээллийн системийн хэрэглээг өргөжүүлж, албан татвар, төлбөрийг онлайн, интернэт, мобайл банкаар шууд төлдөг тогтолцоонд шилжүүлэх, албан татвар, төлбөрийн орлогын төрөл тус бүрээр нэг данстай болж, орлогын мэдүүлгийг нэг загварт оруулах ажлыг арилжааны банкуудтай хамтран зохион байгуулна.

4. Автотээврийн хэрэгслийг албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр төлж, албан журмын даатгалд даатгуулсны дараа техникийн хяналтын үзлэгт хамруулан нэгдсэн нэг наалт олгох бөгөөд энэ наалт нь гаднаасаа уншигдах боломжтой чиптэй байна.

5. Гудамж замд суурилуулсан телекамерийн тусламжтайгаар тогтоосон хугацаанд албан татвар, төлбөрөө төлөөгүй, даатгал, оношлогоонд хамрагдаагүй автотээврийн хэрэгсэл эзэмшигчдийг илрүүлэн эзэмшигчийн бүртгэлийн хаягаар хууль тогтоомжинд заасан хувь хэмжээгээр торгууль ногдуулах ажлыг ЗХУТ зохион байгуулна.

Албан татвар, төлбөр хураах ажлын зохион байгуулалт

Албан татвар, төлбөр хураах ажлыг төрийн үйлчилгээг татвар төлөгчдөд хөнгөн шуурхай хүргэх зарчмын дагуу нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж, нутаг дэвсгэрийн зарчмаар явуулна.

Иргэд, ААНБ, хуулийн этгээдүүд Улаанбаатар хотод бүртгэлтэй өөрийн нэр дээр байдаг хөдөө орон нутагт байгаа бүх төрлийн автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг харьяалах татварын албаны дансанд төлнө.

Импортоор оруулж ирсэн автотээврийн хэрэгсэлд шинээр улсын дугаар авахдаа, шилжилт хөдөлгөөн хийлгэхдээ албан татвар, төлбөрөө төлж, даатгал, оношлогоонд хамрагдсан байна.

“Нийслэлийн авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах журам” шинэчлэгдэн Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан гарсан. Хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй.

Албан татвар, төлбөрөө хуульд заасан хугацаанд төлөөгүй, албан журмын даатгалд даатгуулаагүй, техникийн үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгсэл эзэмшигчдэд Нийслэлийн Замын цагдаагийн газар хяналт тавьж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй, хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажиллана.

Хугацаа

Албан татвар, төлбөр хураах ажлыг нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд:

- Албан татвар, төлбөр хураах ажлыг хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс 5 дугаар сарын 31-ний хооронд;
- Хариуцлага тооцох хяналт шалгалтыг 2015 оны 6 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.